

Амар жаргалын үндсийг тасална.
 Амьтны мөр огторгуйд үгүй
 Ариун санаанд хор үгүй
 Алдар цууд мөнх үгүй
 Ачтан хүнд хор үгүй
 Зан үйл үгүй бол тарничийн гэм
 Завсрын хов их бол үйлсийн гэм
 Залхуу хойрго бол язгуурын гэм
 Зальхай сэрэмжгүй бол сахилгын гэм
 Хэмжээгүй самуурах хатагтайн гэм
 Хармын сэтгэл өглөгчийн гэм
 Ханашгүй жаргах сэтгэлийн гэм
 Хамгийн гэм нь хилэнцийн гэм
 Бусдыг хөнөөн амийг таслах
 Бусдыг мэхлэн худал хэлэх
 Бусдын эдийг хулган авах
 Бусдын эхнэрийг хууран дагуулах
 Бузар булай тэр агаад
 Булшлагдах тавилан тэр бүлгээ...

Д. ДАШДОРЖ
Д. ЭРХЭМБАЯР

«МИЛЫН НАМТАР»-ЫН
 ДӨТГӨӨР БҮЛЭГ

**ДЭЭДЭД БОЛСОН АМАРЛИНГУЙ
 МУУ ГАСЛАНГААС ГЭТЭЛГЭСНИЙ
 ЗОХИОЛ БУЮУ II ХЭСЭГ**

1. Уйдаx хийгээд магад гансарахын үүднээс билгэ төгөлдөр багштай уулзсаны зохиол.
2. Гэгээнээс юу зарлигласныг авах бөгөөс зовлонд сэтгэл гутарсныг зарлигт шүтээд хилэнц, түйтгэрийг хоцроолгүй судалсаны зохиол.
3. Энэрэл нигүүслэхүйд даган барьснаас боловсруулан гэтэлгэх увидсыг олсны зохиол.
4. Тэр ямагт (миларайба) багшийн дэргэд бясалган анхаарал онолын ногоо (эрдэм) мэндэлсний зохиол.
5. Увидасанд өөрөө аяндаа багтан орохын цагт зүүдэн мөрийн дохиог сануулснаар үгэн дамжлага увидас олох бөгөөс багшийн дэргэдээс заларсаны зохиол.
6. Ер бас шалтгаанаар орчлонгийн шим үгүйд гэрэл тодорхой тул бүтээлийг сэтгэлдээ тангарагласны зохиол.
7. Багшийн зарлигийг бүтээхийн тулд энэ нас оюунаа зориулах бөгөөс чин зориг хийгээд бэрх хатууг чандлан алмайралгүй аглагт (ууланд) бясалгасны зохиол.
8. Тэр мэт бясалгасан тул анхаарал онол арвидан дэлгэрэхэд одсоноос туйлд нь хүргэх бөгөөс бүтээлийн үрээр шашин-амьтны тус хайрласны зохиол.

9. Тийн судлах үйлсийн зохиолыг төгсгөснөөс амьтан нигуудыг номын тулд шаардан дүрс бие, номын төвт шингэсний зохиол хийгээд ёсон бүлгийн анхных болой.

ДЭЭДЭД БОЛСОН АМАРЛИНГУЙ МУУ ГАСЛАНГААС ГЭТЭЛГЭСНИЙ ЗОХИОЛ БУЮУ УЙДАХ ХИЙГЭЭД ГАНСАРАХЫН ҮҮДНЭЭС БИЛЭГ ТӨГӨЛДӨР БАГШТАЙ УУЛЗСАНЫ ЗОХИОЛ.

Райнгүнва бас багштан, буяны үйл зохиосон гэж зарлиглан дээдийн номоос зохиос үгүй тул Богд (та) ном лугаа уулзсаны шалтгаан ямар мэт нэгэн гарсан гэж айлтгах тул;

— Богдын гэгээнээс, би хараал, мөндөр, зүхэлийг судлаад номыг дурдах дэндсэн тул өдөр хоолыг эс дурдахад хүрвээс суухыг чин зүрхнээс үл хүснэ буюу сууваас явахыг чин зүрхнээс хүснэ. Шөнө нойр эс хүрэхүй уйсах хийгээд гансрах болохной ч номыг үзэхүйд үл чадна.

Багшийн өлмийн хүндлэлийг үйлдэх бөгөөс суухын агаараас номыг үйлдэх арга нэгэн ямар мэтийг үйлдэх вэ? хэмээн санаа хатуу үргэлжид тоногдолсон байхын цагт; багшид (байх) хамаг бүгд барагдахуйд өгч үйлддэг өглөгийн эзэн болсон идээ, эдийг бүрдүүлэх хийгээд бишрэлт гайхамшигт нэгэн байсан тэр, өвчин хатуу нэгэнд баригдсанаас багшийг дэрний сахиулд урин залахад хүрсэн тэрээс 3 хоног өнгөрөхүй лүгээ багш царайгаа барчийлган барайлагсаар нэгэн морилон ирэхүйд;

Багш тан лугаа би адил царайгаа барчийлган барайлгасаар юу болов гэж айлтгасанд; Багш хуран үйлдсэн бүхэн мөнх бус байгаа урьд шөнө миний өглөгийн эзэн баясгалант тэр ч үхэж одсон тул энэ орчлонд сэтгэл нэгэн уйсах мөн.

Ер хөгшин хүмүүн би ч залуу шүд цагаанаас үс буурал хүртэлд хараал, зүхэл, мөндөр 3-т гагцхүүд үйл үйлдэв. Хүвгүүн чи ч нас залуугаасаа хараал хийгээд мөндөр буулгах тул хилэнц ихийг хураасан тэр бүхэн ч миний өөрийн дээр (толгой) ирэхүйд байгаа гэж зарлиглав.

Амьтан тэр нигуудыг багш өөрөө өндөр язгуур хийгээд тонилгохуйд эс татах мөн буюу гэж айлдсан тул амьтан нигуудыг бодит номын мөн чанарт мөн хийгээд байдал өндөр язгуур лугаа тонилгохойд татахуй эрхэм орон нэгэн ариун буй, зан үйл ямагтыг ч ухаарах.

Тэр нигууд утга хийгээд үгэндээ үлдсэнээс шалтгаан гарахын цагт тус асаахуйг татан, олон ямагт аяндаа үл байгаа тул эдүгээ би шалтгаан чадахуй ном нэгийг үйлдэх мөний тул чи миний хүвгүүн шавь нигуудыг тэтгэ! Би чамайг өндөр язгуур хийгээд тонилохын мөрийн сэжүүрээс барих нэгэнийг үйлдэнэ болой.

Бас болбоосуу чамайг өөрий чинь ном тэрээр би ч өндөр язгуур хийгээд тонилгохын мөрийн сэжүүрээс барих нэгэнийг үйлдье. Би зохиолдохын шалтгаан нигуудыг судална гэж зарилгасаны тул миний хүсэл бүтэх бөгөөс би номыг үйлдэхүйд айлтгалыг айлтгахад;

— Тэгэвч чиний нас бага, чин зориг хийгээд сүжиг бас эрхэм нэгэн байгаа тул ном асар ариун нэгэнг үйлдэгтүн гэж зарлигласнаас Ярлүнгын (аймаг) тэрэм нийлсэн хайнагийн ачаа нэг хайнаг лугаа сэлтэстийг хайрлах бөгөөс Зан-ран нэрт (газрын) хэмээхүйд (орон) лам Рондонлхагай нэрт дээдийн ном «их төгсгөхүйн зэрэг»-т мэргэн бөгөөд бүтээл ологч нэгэн байгаа. Тэнд хүрээд бүтээлийг үнэхээр нэгийг үйлдэгтүн! гэж зарлиглав.

Би ч багшийн иш үзүүлсэн мэт Зан-ран нэрт хэмээх (орон)-д ирснээс мухарлан асуусан тул багшийн хатагтай хийгээд шавь зарим байгаа нигууд өгүүлрүүн; энэ эх (их) орон хийд бус бөгөөд багш эдүгээ энд байхгүй. Няндан ринан нэрт хүү (бага) хийдэд морилж байгаа хэмээв.

Тэгэвч би багш Юндантожлийг чиглэн ирсэн нэгэн мөн тул уулзуулах нөхөр төгөлдөр лүгээ үйлдэх учир байдал нигуудыг дэлгэр өгүүлсний тул;

— Хатагтай, шавь нэгэн миний замын үзүүрийг чиглүүлснээр Нянданринан нэртэд багшлугаа бараалхан, тэрэм хийгээд хайнагийн шарыг мутрын шүтээнд өргөв. Би Нямладод нэрт газраас ирсэн хүмүүн хүлэнцтэн нэгэн мөн, орчлонгоос энэ насанд гэтэлгэх нэгийг айлтгая хэмээхүйд;

«Багш гэгээнээс, миний дээдийн ном «Төгсгөхүйн зэрэг их» энэ ёзоор нь гарах хялбар, үзүүрийг олох нь төвөггүй, үр нь боловсрох хялбар, өдөр бясалгаваас өдөртөө бурхан, шөнө бясалгаваас шөнөдөө бурхан хувь төгөлдөр үйлийн залгамжаатанд бясалгахын хэрэггүй сонссоноор гэтлэхүйн эрхтэн эрхэм энэ адилын номын хувьт мөнийн тул өгнө гэж зарлиглан, авшиг хийгээд увидас хайрласнаас миний сэтгэлд би анханд хараал үйлдэхээр хоног 14-т шинж гайхамшигтыг гаргасан, мөндрийг хоног 7-д буулгаж болж байсан эдүгээ хараал, мөндөр буулгах ч хялбар номыг өдөрт бясалгаваас өдөртөө бурхан, шөнө бясалгаваас шөнөдөө бурхан хувь төгөлдөр үйлийн залгамжаатан сонссоноор баясалгахын хэрэггүй энэ адил лугаа учрах ёсоор би ч үйлийн залгамжаатан нэгэн мөний учир байгаа хэмээн омогшрол лугаа сэлтэстэн эс бясалгахуйд байгаа тул;

— Эдүгээ чи өөрөө Лховрагийн Довоо-лүн нэрт хийдэд Энэтхэгийн их бүтээлчин Наробын шавь төрөлхтний дээд дуун орчуулагч-лозова Марба нэрт хэлмэрч нууц тарнийн бүтээл олсон, 3 газар, (дээр, дунд, доор). тэнцэхийн хань лугаа хагацсан нэгэн байгаа тэр лүгээ чи өөрөө урьд насаар барилдалгаат байгаа тул тэнд одогтун гэж зарлиглав.

Тэнд би дуун орчуулагч Марбын алдрыг сонсохын төдийхөн сэтгэлд өгүүлж гүйцэшгүй баясах лугаа биеийн шар үс бүхэн хөдлөхүй амгалан буй үл хямрахын сүсэг бишрэл хэмжээлшгүй гарсны тул оюун нэгэн үзүүрт төвлөрсөнөөс замын завдлага хийгээд боть (ном) адил буйг авах бөгөөс санасанчилэнх янагш, тахил, хүртэл багш лугаа бараалхах бөгөөс гэгээнийг (нүүр) харах болбоосуу ямар нэгэн буй байгаа бол гэж бодох бөгөөд хүрсэн тул;

Би Довоолүнд маргаар (маргааш) хүрэх буйн үдэш (шөнө) Марба (лам)-ын зүүдэнд Банчин Нароб морилох бөгөөс авшиг дурдан, уг биндэръяагаас бүтсэн очир таван салаа хир өчүүхэн наалдсан байгаа нэгэн хийгээд алтан хунхат рашаан дүүрэн нэгэнийг хайрлах бөгөөс Очир Тэрийн хирийг хунхны рашаанаар угаагаад ялсан тэмдгийн үзүүрт залагтун!

Амьтан нигууд бишрэн үйлдэх мөн тул өвөр бусдын тус бүтээх мөн гэж зарлигласнаас огторгуйд залрах буюу багшийн зарлигласанчилэн хунхны рашаанаар очырыг ариутган угаах бөгөөс ялсан тэмдгийн үзүүрт хийсгэсэн учир очырын гэрэл ертөнц хотлоор түгэх бөгөөд зургаан зүйлийн амьтан нигуудад тусаж, зовлонгүй амгалангийн байдлаас богд Марба өөрөө хийгээд ялсан тэмдэгт амьтан бүхнээр мөргөл эрэх бөгөөд тахил магтаалд өргөн, бурхад нигуудаар ялсан тэмдгийг амилуулан зохиогтун гэж зүүдлэв.

Таалал өчүүхэн хямрахын агаараас үүр цайсан хийгээд таглан баясах бөгөөс цацархуй ямагт гарсны байдалд хатагтай зоогийг барихуйд иржүү болой.

— Лам тан (хатагтай) урьд шөнө миний зүүдэнд умар зүгийн үржингийн орноос мөн (ирсэн) хэмээх эхнэр 2 болор суварга гадуураа хир өчүүхэн нэгэн наалдсанг авч ирэх бөгөөс;

— Эцэг (түвдэд багшийгаа эцэг гэж хэлнэ) багш Наробын зарлиг иш мөний тул суварга энийг амиллуулаад өндөр уулын оройд залаг-

тун! хэмээв. Эцгийн гэгээнээс ч суварга тэрийн амилуулга оршуулахыг Банчин Наробаар бүтээлгэх мөн буюу, багшийн зарлигийг бүтээх хэрэгтэй гэж зарлиглан, суваргыг хунхны рашаанаар ариутган угаах тэргүүтэн амилуулга оршуулах цагт дэлгэр зохиож тэрийг уулын оройд агуулах тул суварга тэрнээс нар, сар мэт гэрэл их хийгээд суварга тэр адил олонтойд цацарч бөгөөтөл уулын орой бүхэн дүүрч гонир (тусгай хэрэглэгч) эхнэр тэр 2-ыг үйлдэх бөгөөд байгаа нэгэнийг зүүдлэв, юу мөн бэ? гэж айлтгасанд:

— Зүүдний (Марба лам) утга зохилдуу байгааг таалах бөгөөс таалал машид баясах нэгэн гарсан болохной ч, зүүд баригдахгүй учир чухам болох, хаанаас ирснийг үл мэднэ гэжээ. Би замын хажууд тарианы шуудуу ухахаар явах тул завдлагааг зэх гэж зарлиглав.

— Үйлийг (хатагтай өгүүлрүүн) хүмүүний үйл энэ төдийн нэгэнийг үйлдэхээр лам та их ямагт үйлд морилбоос бид нигүүдийг бүхэн хочлох нэгэн ирэх тул азнагтун гэж айлтгал өргөх болохнойч эс сонсон лам, өөрөө морилсноос надад архи ахиухантай аваад ир гэж зарлигларуун;

Хунх дүүрнийг аваачсанд энэ миний өөрийн уух мөн, тэр зочны хувийг аваад ир гэж зарлиглав. Бас хунх дүүрэнг аваад ирэх тул тэрийг газарт булаад овоодой тэрээр бүтээж бөгөөс шуудуу ухахын агаараас алжаал ямагтыг зохиох хийгээд түр амсхийн сууж байхад би ч Лховрагийн адгаас учирсан хүмүүн бүхнээс асуун төрөлхтний дээд Марба лозова (хэлмэрч) хаана байна вэ? хэмээн асуух бөгөөс хүрсэн тул мэдэж байгаа хэмээх нэгэнч эс гарсан. Довообүнгийн (хийд) харагдах даваан дээр ирэхүйн цаг хүмүүн нэгэн ирснээс урьдынх мэтийг асуух тул

— Марба хэмээх байгаа, төрөлхтний дээд Марба лозова хэмээхүйг мэдэхгүй; Тэгвээс Довоолүн хаана байна вэ хэмээхэд;

— Довоолүн, хийд, миний эцгийнх мөн хэмээх харагдах болсонд эцэг хийдэд хэн морилж байна вэ? хэмээхүйд;

— Марба тэр л буй хэмээдэг, тэрээс бусдыг мэдэхгүй хэмээрүүн;

— Зарим нь Марба лам хэмээхүй ч бөгөөс байдаг гэлцдэг. Багшийн орон мөнийг лавтайд мэдээд давааны ам энийг ямар даваа хэмээхэд;

— Энэ давааг номын даваа хэмээдэг. Номыг даваанаас ламын (Марба) суудаг хийд харагддаг шүтэн барилдлага машид сайн хэмээн баясах нэгэн гарсан.

Тэрээс ч дээш өгсөх бөгөөд ирсэн тул мал хариулагч олон ямагт байв. Тэд нигуудаас асуухад настай зарим нь өгүүлрүүн;

— Мэдэхгүй хэмээв. Тэд нигуудын дотроос залуухан сэтгэлд зохист ааш хийгээд царай сайн, яриа хэл түвшин, тослог үстэй нэгэн өгүүлрүүн,

— Бидний эцэг аажаа хэмээх мөн буюу. Тэр мөнөөсүү бидний эцэг бид өөрийн эд алин буй алтыг арилжаагаар энэтхэгийн оронд авч одоод янагшад гарын бэлэг боть (ном) их бага олонтойг авчирснаас ирдэг буй нэгэн байлаа. Урьд үйл үйлдэхүйн учиргүй, тэр өнөөдөр эцэг (аажаа) шуудуу ухаж байгаа хэмээв.

— Лавтайд Шинжвээс адил мөн бөгөөс тэр лозова их шуудуу ухдаг өөрөө биш буюу хэмээснээс хүрсэнд замын хажууд нэгэн бандида лагшин махлаг тарган нүд том сүр ихтэй нэгэн шуудуу ухах бөгөөд байхыг харсан даруйгаа үгийг үл өгүүлэлгүй баясгалан жаргалан санаж сэтгэшгүйн байдалд энэ насны санаа бодол балартан түр нэгэн муужирахуйд байв.

Тэрээс миний дэргэд мөнөөс, орон энэ цогт Наробын бодитой шавь, дуун орчуулагч Марба лозова тэр морилон байгаа юу? хэмээн асууваас, тэр энд байна гэж хариулсан тул;

— Бандида тэр толгойгоос хөл хүртэлд өнөт нэгэн харах бөгөөс;

- Чи хаанаас ирсэн мөн? юун хүн ямар хэрэгтэй вэ? гэж зарлигласанд;
- Би Занладодын хүмүүн их хилэнцэт нэгэн мөн бөгөөд тэд сайрхаг бүхэн машид их дэндүүлсэн тул дээдийн ном ямагтыг айлтгахаар ирсэн мөн гэж айлтгасанд;
- Тэгвэл би Марба лугаа учруулъяа, чи өөрөө миний шуудууг ухагтун! гэж зарлиглаад овоодойн дороос газар булсан архийг гаргах бөгөөс өгөөд тус шимтэй нэгэн гарна гэв. Шуудуу энийг ухагтун гэж хэлээд бандида тэр буцаад одсон хийгээд архийг үлдээлгүй уух бөгөөс шуудуу нижгээд янагшад ухсан тул тэр мал хариулж байсан нэгэн царай дулаахан хүү өчүүхэн тэр дуудаж ирэх бөгөөс;
- Лам өргөөний дотор ор гэж зарлиглаж байна хэмээх тул баяссан болой.
- Тэр миний учруулсан зүйлийг дуусгах хэрэгтэй байгаа гэсэн тул би ч ламын шуудуу ухсаны залгамжаа энийг гүйцээх ямагтыг үйлдээд өчүүхэн нэгэн үлдсэн байгаа тэрийг ухав. Тариалан тэрээр миний багш лугаа уулзсаны зохиолдохын шалтгааныг үйлдсэн тул тариалангийн нэр «зохиолдохын шалтгаан»-д тогтсон болой.
- Зун тариалангийн захаар, өвөл голоор зам байдаг нэгэн байв. Тэрээс би хүү өчүүхэн тэр лүгээ эвсэх бөгөөс дотор хүрсэн тул урьдаас бандида тэр газар болбоос олбог хивс гадартай хоёр давхарлан зөөлөн суудал лугаа сэлтэстийн гурвалжилсаны дээр суусан бөгөөд хамаг биеийн хөлс дааварлан хөмсөг хийгээд хамрын самсааны хонхорт шороо борзойн наалдсан хэвээрээ, сүр бараа ихтэй гэдэс нь урагшаа болхойж унжсан байдлаар сууж байсан энэ урьдын тэр мөн байв. (Марба)
- Лам (багш) хаана байдаг, хэн билээ? хэмээн хараад,
- Лам өгүүлрүүн; миний танихгүй нь аргагүй юм байна.
- Би Марба өөрөө байна, мөргө гэж зарлигдав. Би мөргөл эрээд өлмийг орой зулайгаараа авах бөгөөс;
- Лам эрдэнэ! би Нямлададын хүмүүн их хилэнцтэн нэгэн мөний тул бие, хэл, сэтгэлээ ч өргөө, хоол, хувцас, номыг ч ламд айлтгаяа! энэ насаар бурхан болгохыг таалал нигүүслэхүйдээ барихын айлтгалыг айлтгасанд;
- Лам гэгээнээсээ, их хилэнцтэн мөн гэвүү? надад хамаагүй. Би хилэнц тэргүүнтэнг чамд тавьсан бусаа. Чи хилэн, юуг үйлдсэн бэ? гэж зарлигдав.
- Учир шалтгаан нигуудаа дэлгэр айлтгасан тул;
- Байна дээ, алин мэт болбоосуу бие, хэл сэтгэлээ өргөдэг тэр сайн. (Би) хоол, хувцас, ном гурав тэр бүхэн байхгүй.
- Эс бөгөөсүү хоол, хувцсыг өгнө, номыг бусдаас эрэмүй. Эсхүл номыг өгнө, хоол, хувцсыг бусдаас олох уу? тэр хоёрын аль нэгийг сонго!
- Би номыг өгөхгүйн талаас энэ насаараа бурхан болох, болохгүй чиний өөрийн чинь чин зоригоос шалтгаална гэж зарлиглав.
- Тэгэвч ламын дэргэдээс номыг авахаар ирсэн мөн тул хоол, хувцсыг бусдаас олох хүртэлхийг айлтгаснаас ном (судар) нэгэн тэр бүгдээ байшинд дөхүүлэн тавих тул чиний ном зэтгэртэй тэрийг сөргөө гарга! Миний бурхан, тахил нигуудад ханиад ирнэ гэж зарлиглав.
- Миний номын дотор хараалын ном байсан тул уршиг тарина хэмээх гарсан. Би өөрийн байгаа газар тэнд лхадаглан суудаг байв.
- Ээжий (Марба ламын хатан) хоол ундаан жаргалантайг өгнө гэж зарлигласан болой.
- Лам лугаа бодитой учирсаны зохиол бөгөөс анхных болой.

Д. ЦЭДЭВ

Түрүүч нь 1991 оны № 1, 2-т,
Үргэлжлэл бий.